



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/597

Хэрлэн сум

Цагийн хязгаарыг  
шинэчилэн тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, 21 дүгээр зүйлийн 21.1.9, 22 дугаар зүйлийн 22.1, 22.2, 23 дугаар зүйл 23.1, Захиргааны ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудын үйл ажиллагаа эрхлэх шинэчилсэн цагийн хязгаарыг хавсралтаар тогтоосугай.


2.Бүх шатны сонгуулийн санал авах өдөр, санал авах өдрийн өмнөх болон дараагийн өдөр буюу 3 хоног аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдахыг хориглосугай.

3.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа эрхлэх цагийн хязгаарын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар(Дэд хурандаа Э.Жавхлантөгс), Сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.


4.Захирамжийг холбогдох хууль, журмын дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т даалгасугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын цагийн хязгаар” тогтоох тухай А/510 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023  
оны 11 дугаар сарын 29-ны  
А/597 дугаар захирамжийн хавсралт

**СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЛЭХ ШИНЭЧИЛСЭН ЦАГИЙН ХЯЗГААР**

№	Худалдаа, үйлчилгээний нэр	Ажиллах цагийн хязгаар
1	Худалдах тусгай зөвшөөрөл эзэмшигч	08:00-00:00
2	Үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч	08:00-04:00